

2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“УЛААНБААТАР БҮК” ХК нь анх 1984 онд “Байшин Үйлдвэрлэх Комбинат” нэртэй улсын үйлдвэрийн газар хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, тухайн үедээ Улаанбаатар хотын орон сууцны барилга байгуулалтын 70 орчим хувийг, Дархан, Эрдэнэт зэрэг төвийн бүсийн хот суурингуудын бүтээн байгуулалтыг бетон зуурмаг болон төмөр бетон хийц эдлэлээр хангаж ирсэн байна.

Ерөнхий мэдээлэл

Компанийн оноосон нэр	“Улаанбаатар БҮК” ХК
Үүсгэн байгуулагдсан огноо	1996-04-27
Албан ёсны хаяг	Баянгол дүүрэг, 20-р хороо, “УБ БҮК” ХК – ийн байр
Шуудангийн код	18031
Ажилчдын тоо	117
Дүрмийн сан	131’547’500 төгрөг
Гаргасан хувьцаа * нэрлэсэн үнэ	131’547’500 ширхэг * 1 төгрөг
Улсын бүртгэлийн дугаар	9010001027
Регистрийн дугаар	2041219
Компанийн дүрэм: ХЭХ шийдвэрийн огноо, дугаар	2017 он 04 сар 26 өдөр №2017/06
Утас:	976-70001182
Факс:	976-70001713
Вэб сайт:	http://www.ubbuk.mn
И-мэйл:	info@ubbuk.mn

Үйл ажиллагааны чиглэл

- Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр
 - Төмөр бетон хийц үйлдвэрлэх;
 - Даацын металл хийц эдлэлийн үйлдвэрлэл;
 - Бетон зуурмагийн үйлдвэрлэл;
 - Элс хайрга бутлан ангилах үйлдвэрлэл;
- Өргөх байгууламжийн чиглэлээр:
 - ачаа өргөх кран, төрөл бүрийн өргүүрийн /барилгын өргүүр, манипуляторт кран; сагстай өргөгч/ угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ;
 - өргөх байгууламж, түүний эд анги үйлдвэрлэл;
- Төмөр замын чиглэлээр:
 - төмөр замын дээд бүтэц үйлдвэрлэх /Төмөр бетон дэр үйлдвэрлэх/;
- Барилга угсралтын чиглэлээр:
 - цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын ажил (1-16 давхар хүртэл);
 - цамхаг, тулгуур, түшиц хана, яндан цамхаг зэрэг 30 м хүртэл өндөр угсармал ба

цутгамал бетон, төмөр бетон, ган бүтээцтэй байгууламжийн ажил;

Үйл ажиллагааны өөрчлөлт, шилжилт

2017 оны байдлаар үйл ажиллагааны өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй болно.

Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлсэн байдал

2017 оны байдлаар үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэлт хийгдээгүй.

Хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой гэрээ, хэлцэл

2017 оны байдлаар хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой аливаа гэрээ, хэлцэл хийгдээгүй. Компанийн хөрөнгийн үнийн >10% тэнцэх хөрөнгийн өөрчлөлтгүй.

Тайлант хугацааны онцлох үйл явдлууд

- Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбатад 2017.03.10-ны өдөр автозамын салбарт нэвтрүүлэх боломжтой шинэлэг технологийг судлах зорилгоор төмөр бетон хийц, эдлэл бэлтгэн боловсруулдаг “Улаанбаатар БҮК” ХК-ийн үйл ажиллагаагаа танилцуулав.

- УИХ-ын гишүүн, Их Британи-Монголын парламентын бүлгийн гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, тус бүлгийн дэд дарга, УИХ-ын гишүүн Н.Учрал, Их Британийн Гадаад Худалдааны сайд, Парламентын гишүүн Марк Гарниер, Их Британийн Элчин сайд Катрин Арнолд нар УБ-БҮК” ХК-ны Английн RMS технологиор

- Мөн байгууллагын стратегийн чухал түншүүд болох “Оюу Толгой” ХХК, Vossloh, Termigas Impanti Technology компанийн төлөөлөгчдийн уулзалтыг зохион байгуулж үйлдвэртэй танилцуулсан.
- Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж байгаа БНХАУ-ын засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр УЛААНБААТАР-МАНДАЛГОВЬ цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станцын барилга угсралтын ажилд төмөр бетон эдлэл бэлтгэн нийлүүлж байна.



- Төмөр бетон хийц эдлэлийн чанарыг сайжруулах зорилгоор ХБНГУ-ын SES expert байгууллагын мэргэжилтэн Gerrit Bier-ийг урилгаар авчирч зөвлөгөө авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 2017 онд 40ш нарс, 3 гацуур 60 улиас мод тарьж, усалгааны систем хийсэн.
- Компанийн хувьд Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд гол үүрэг гүйцэтгэж буй “Оюу Толгой” ХХК-ийн бүтээн байгуулалтад оролцох, тэдний ханган нийлүүлэгчээр бүртгүүлэн шууд гэрээ байгуулан хамтран ажиллаж эхлээд байна.

Санхүүгийн тайлангийн дүгнэлт

Нийт хөрөнгө 2016 оны мөн үетэй харьцуулахад 1.7%-аар буурч, эргэлтийн хөрөнгө 32%-р өссөн. Эргэлтийн хөрөнгийн өсөлт нь ачилт хийгдээгүй бэлэн бүтээгдэхүүн өссөнтэй холбоотой.

Нийт өр төлбөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27%-аар өссөн нь урьдчилж олсон орлогын (гэрээний урьдчилгаа төлбөр) өсөлтөөс хамаарч байна. Хуримтландсан ашгийн бууралт эздийн өмчийг 6%-аар бууруулж байна.

Балансын бүтцийн хувьд: Өмнөх онтой харьцуулахад эргэлтийн хөрөнгө 21%-аар нэмэгдэж, эргэлтийн бус хөрөнгө 5%-аар буурсан. Нийт эх үүсвэрт өр төлбөрийн эзлэх хувь хэмжээ 5%-аар өссөнтэй холбогдуулан эздийн өмчийн эзлэх хувь 85%-аас 80%, болж 5%-аар буурсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт ашгийн маржин 23%-аас өсч 26%-тай тэнцсэн байна.

1	2017 оны жилийн санхүүгийн тайлан, сая төгрөг		
2	Санхүүгийн тайлан	Эхний үлдэгдэл 2017 оны 01 сарын 01 өдөр	Эцсийн үлдэгдэл 2017 оны 12 сарын 31 өдөр
3	Санхүүгийн үзүүлэлтүүд	Санхүүгийн тайлангийн хуулбар	
	Нийт хөрөнгө	37,381	36,755
	Өр төлбөрийн нийт дүн	4,766	6,072
	Эзэмшигчдийн өмчийн дүн	32,615	30,683
	Нийт хувьцааны тоо ширхэг, ширхэг	131,547,500	131,547,500
4	Орлого үр дүнгийн тайлангийн үзүүлэлт		
	Нийт борлуулалтын орлого	4,707	5,032
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,639	3,706
	Нийт ашиг	1,068	1,326
	Цэвэр ашиг	-2,078	-1,931
	Ногдол ашиг	Энгийн хувьцаа	
		Давуу эрхийн	
	Нэгж хувьцааны дансны үнэ	Эзэмшигчдийн өмч / хувьцааны тоо ширхэг	Эзэмшигчдийн өмч / хувьцааны тоо ширхэг
	Хувьцааны тухайн өдрийн хаалтын ханш	1 төг	450 төг



Санхүүгийн харьцаанууд

Үзүүлэлт	2016 оны гүйцэ тгэл	2017 оны Төл:	2017 оны Гүйц.	Өсөлт/ Буура лт %
Ашиг/Алдагдал	-2,078	-2,053	-1,932	6%
Нийт ашгийн маржин	23%	27%	26%	-4%
ЕБИТДА*	-399	-338	-199	41%
Нийт хөрөнгийн өгөөж (ROA) ЦА/Нийт хөрөнгө	-5.5%	-5.9%	-5.3%	10%
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж (ROE) ЦА/ЭӨ	-6.4%	-6.7%	-6.3%	6%
Нийт хөрөнгийн эргэц Орлого/Нийт хөрөнгө	14%	19%	14%	-26%
Нэгж хувьцааны өгөөж (EPS) (ЦА-ДЭХ НА)/Энгийн хувьцааны тоо	-15.8	-15.6	-14.7	6%

Хувьцааны арилжаа, үнэлгээ

Компаний хувьцааны арилжааг 2017 оны 1 дүгээр сараас 2017 оны жилийн эцсийн байдлаар орууллаа.

ГАРГАСАН ХУВЬЦАА	131,547,500
ХУВЬЦААНЫ ҮНЭ	
Хаалтын үнэ	450
Дээд үнэ	600
Бага үнэ	320
Дундаж үнэ	
КОМПАНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	59,196,375,000
АРИЛЖАА ХИЙГДСЭН ТОО	69
АРИЛЖААГДСАН ХУВЬЦААНЫ ТОО	125,711
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН	64,066,195

